



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/38

Сүхбаатар сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3."в" Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 19 дүгээр зүйлийн 19.5, 20 дугаар зүйлийн 20.1.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашигт малтмал газрын тосны газрын 7/6045 албан тоотын дагуу хавсралтад заасан "Чанартай элс" ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Дээрх аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж үйл ажиллагааны явц, байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/, Баруунбүрэн сумын Засаг дарга /Г.Түмэн-Өлзий/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ